



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№59 /273/

2022.03.25

Г.Сайханбаяр: ТА БҮХНИЙ БҮТЭЭЛЧ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЯМАГТ ДЭМЖИЖ АЖИЛЛАХ БОЛНО



тэмдэглэн өнгөрүүлэх нь зүйтэй" гэв. Түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэр бум мод" үндэсний хөдөлгөөнд идэвхтэй оролцох, цэргийн алба хаагчидтай цэргийн дүрмийн дагуу харьцах, сахилга зохион байгуулалтыг сайжруулах, хяналтыг нэгдмэлжүүлэх, офицер, ахлагч, цэргүүдийн бие бялдрын бэлтгэлжилт, чадварыг дээшлүүлэхэд онцгойлон анхаарахыг үүрэг болгов.

Уулзалтын төгсгөлд тэр бээр "Цэргийн анги, салбарын үйл ажиллагаа албан тушаалтнуудын ухамсар, хандлага, сэтгэл, хичээл зүтгэлээс ихээхэн хамаарахыг ойлгож, шинэ санаа, бүтээлч хандлагыг урамшуулан дэмжиж сахилгын зөрчилгүй хамт олныг бүрдүүлж ажиллах ёстой. Та бүхний гаргасан санаачилга, бүтээлч ажиллагааг ямагт дэмжиж хамтран ажиллах болно" гээд зарим офицер, ахлагч, ажилтан албан хаагчийг төрийн одон медаль, Зэвсэгт хүчний 100 жилийн ойн медаль, салбарын шагналаар шагнасныг гардуулан өглөө.

Монгол Улсын засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр БХЯ-ын Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга хурандаа Ч.Гандирваа, ЗХЖШ-ын Бодлого стратеги, төлөвлөлтийн газрын дарга бригадын генерал Ц.Гандорж, Хуурай замын цэргийн командлагч хошууч генерал Б.Амгаланбаатар, Дорнод аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн тэргүүтэй орон нутгийн удирдлагууд Зэвсэгт хүчний 327 дугаар ангид ажиллалаа. Батлан хамгаалахын сайдыг ангийн Хүндэт харуул ёслол төгөлдөр угтсан авсан юм.

Тус ангийн захирагч хурандаа Н.Цэцэнхүү ангийн товч танилцуулга, үүрэг гүйцэтгэлт, өдөр тутмын үйл ажиллагаа, цэргийн сургалт бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ, бүтээн байгуулалт дахь оролцоо, дэвшүүлсэн зорилго зорилт, өнгөрсөн онд хийж хэрэгжүүлсэн зарим бүтээлч ажил, цаашид хийхээр төлөвлөсөн ажлуудын талаар мэдээлэл өгөв. Түүнчлэн ангид тулгамдаж байгаа хэд хэдэн асуудлыг хөндсөн юм.

Тухайлбал, ихэнх барилга байгууламжууд 1974-1978 онд баригдсан, насжилт уртассан, өнөөдрийг хүртэл бүрэн хэмжээний их засвар хийгдээгүй, үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй болсон гэдгийг хэллээ. Мөн ангийн тусгай хэрэгцээний газрыг нэмэгдүүлэх, орон нутагт албан тушаалын орон сууц барих, шинээр баригдах цэргийн гал тогооны барилгыг аймгийн нэгдсэн бохирын шугамд холбуулахад шаардлагатай төсөв хөрөнгийг шийдвэрлэхэд дэмжлэг

үзүүлэх зэрэг асуудлын талаар уламжилж байв.

Тэгвэл Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр зарим асуудлуудын хүрээнд орон нутгийн удирдлагуудтай харилцан санал солилцож, хэрхэн шийдвэрлэх талаар тодорхой чиглэл гаргасан юм. Үргэлжлүүлэн Батлан хамгаалахын сайд ангийн барилга байгууламж, цэргийн байр, хугацаат цэргийн алба хаагчдын амьдарч буй орчин нөхцөлтэй танилцаж тэдний санал сэтгэгдлийг сонслоо. Мөн тус ангийн бие бүрэлдэхүүнтэй уулзаж батлан хамгаалах бодлого, зорилт, салбарын хэмжээнд хийж хэрэгжүүлсэн, цаашид хийгдэх онцлох ажлуудын талаар мэдээлэл өгөв. Үргэлжлүүлэн "Энэ жил Дорнод аймгийн ЗДТГ болон Зэвсэгт хүчний 327 дугаар ангиудыг түшиглэн Батлан хамгаалах бодлогын шинэчлэлийг орон нутагт хэрэгжүүлэх зарим асуудал" сэдвийн хүрээнд цугларалтыг зохион байгуулж байгааг юуны өмнө хэлье. Нөгөөтэйгөөр Батлан хамгаалахын сайд миний бие Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарын үйл ажиллагаа, орчин нөхцөл байдалтай танилцахыг зорьж байгаа. Энэ удаа Зэвсэгт хүчний 327 дугаар анги, 085 дугаар тусгай салбарын үйл ажиллагаатай танилцаж байна. Энэ жил Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн 25 жилийн ой тохионо. Гэхдээ ойг тохиолдуулан төсөв хөрөнгө зарцуулж, ойн медаль дурсгалын тэмдэг гаргахаа болих хэрэгтэй. Үүний оронд түүхийн ном, товхимол бүтээх,



дурсгах, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, ангидаа мод бут тарих, тохижилт хийх зэргээр шинжлэх ухаанч, бүтээлч байдлаар

Үүний дараа Батлан хамгаалахын сайд Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 085 дугаар тусгай салбарт ажилласан юм.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

Өдөр	Шөнө
-1	-18


ӨМНӨД СУДАН

Өдөр	Шөнө
40	29

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,960.00	2,990.0
EUR	3,330.0	3,370.0
CNY	473.00	475.00
RUB	32.00	34.00
JPY	25.30	26.00
KRW	2.46	2.50

ЗУРХАЙ



ХАВРЫН ДУНД ХАРАГЧИН ТУУЛАЙ САРЫН ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ УЛААГЧИН ҮХЭР ӨДӨР

Үс засуулбал:

Эд эдлэл идээ ундаа олдоно

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

06.45-19.11

Барилдлага:

Идэр

Шүтэн барилдлага:

Авахуй

Суудал: Шороо

Энэ өдөр тахиа, могой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй.

Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, хишиг даллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, мал арилжих, гэр бүрэхэд сайн. Эрдэнийг гадагш өгөхөд муу.

Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун зүгт мөрөө гаргавал зохистой.

Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, эдлэл, идээ, ундаа олно.

МЕНИНГИТ ӨВЧИН

МЕНИНГИТ ӨВЧИН ҮЙЛДЭГЭЭС МАШ БОЛНО БОЦАНД ХУВИРЧ ЭРСЭЛТЭЙ ХАЛДАРТ ӨВЧИН.

АГААР ДУСНЫ ЗАМААР БОЛОН ГАР, ХУНСИЙ ЗҮЙСЭЭР ДАМНИН ХАЛДАРЛАГД.

БАЛА НАСНЫ ХҮҮДЭД МЭРГЭ АЖЛАХ ИТГЭ ВЭДЭР БАЙДА.

ИЛРЭХ ШИНН ТЭМДЭГ	СРЬЛЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРТЭСЭД
СЭГТ ӨДӨР ХАЛДВАР	НАЙР КОЛОНЧЛОХ ВЭЛЭГЭГ ҮРЭВЭГ
СӨВӨН	КӨТӨЖИЙН ЗЭВН ЗАРИХСЭЭРЭЙ ШИГЭЭ
СӨЛӨЧ	МЭНГЭТЭЙ ХАЛДАРЫН СЭХЭ ВЭЛЭГЭГ ХАМРАХ
ХӨРӨГӨДӨЛ СЭХЭМЭЭ СЭРГЭТ	СӨРӨ ТАЛААРХ ӨРӨ ТӨМӨ ХАМРАХ
СӨРӨГӨДӨЛ СЭХЭМЭЭ СЭРГЭТ	СӨРӨГӨДӨЛ СЭХЭМЭЭ СЭРГЭТ
ТӨГӨДӨЛ СЭХЭМЭЭ СЭРГЭТ	СӨРӨГӨДӨЛ СЭХЭМЭЭ СЭРГЭТ
СӨРӨГӨДӨЛ СЭХЭМЭЭ СЭРГЭТ	СӨРӨГӨДӨЛ СЭХЭМЭЭ СЭРГЭТ
СӨРӨГӨДӨЛ СЭХЭМЭЭ СЭРГЭТ	СӨРӨГӨДӨЛ СЭХЭМЭЭ СЭРГЭТ
СӨРӨГӨДӨЛ СЭХЭМЭЭ СЭРГЭТ	СӨРӨГӨДӨЛ СЭХЭМЭЭ СЭРГЭТ
СӨРӨГӨДӨЛ СЭХЭМЭЭ СЭРГЭТ	СӨРӨГӨДӨЛ СЭХЭМЭЭ СЭРГЭТ

05 НАСНЫ ХҮҮДЭД ҮГ ХАЛДАВААР ӨВӨСӨН ХӨНӨГӨДӨЛД МАШ ХУРДАН ХҮНДЭГЭД ТҮЛ ЦАГ АЛДАЛГУЙ ЭМНЭЛЭГТ ХАНДАВАЙ!

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСЫЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН
2,272,319 /69.8%/	2,174,350 /66.8%/	1,031,374 31,7%
		113,435 /3,5%/

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
8431 +112	5	8306

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 478,183,956

Эдгэрсэн
Нийт: 412,796,781

Нас барсан
Нийт: 6,133,665

МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДРӨӨР ...

“МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР”-ӨӨР

Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

“Монгол цэргийн өдөр”, Монгол Улсын Зэвсэгт хүчний 101, Монгол цэрэг энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойг тохиолдуулан төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчдын дунд “Цэрэг спортын олон төрөлт” цуврал, “Мөрдөстэй бүсгүйчүүд-2022”, “Буудлага”, “Тэргүүний дууч, жагсаалч салаа”, “Марш тактикийн тусгай бэлтгэлийн аварга тасаг” шалгаруулах тэмцээнийг зохион байгууллаа. Мөн аймгийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Монгол цэрэг-Дэлхийн цэрэг” сэдэвт гар зургийн, их, дээд сургууль, коллежийн оюутнуудын дунд “Цэргийн алба-Эрдмийн алба” сэдэвт шорт шалгаруулах уралдааныг явуулав.

Сэлэнгэ аймгийн Засаг дарга Н.Лхагвадоржийн ивээл дор зохион байгуулсан “Цэрэг-спортын олон төрөлт” цуврал тэмцээнд 7 байгууллагын давхардсан тоогоор 400 гаруй алба хаагчид оролцсон бөгөөд тэмцээний нийлбэр дүнгээр хурандаа Д.Мэндсайхан захирагчтай Хилийн цэргийн 0243, хурандаа О.Батгэрэл захирагчтай Хилийн цэргийн 0101, хурандаа Г.Галбадрах даргатай аймгийн Онцгой байдлын газрын баг тамирчид эхний байруудад шалгарлаа.



Баруун хилийн тулгаралтад оролцсон ахмад дайчин Г.Чогсомжав Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Зэвсэгт хүчний 100 жилийн ойн медалиар шагнагдсан бөгөөд шагналыг Цэргийн штабын дарга хурандаа Б.Энхболд, Мандал сумын Засаг дарга Б.Ганболд, 2 дугаар багийн Засаг дарга Н.Гэрэлцэцэг нар гэрт нь очиж гардуулан хүндэтгэл үзүүлээ.

Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудад ажиллаж байгаад тэтгэвэр чөлөөнд гарсан ахмад дайчдын дунд “Цэргийн нөхөр” хийн буудлагын тэмцээнийг зохион байгууллаа.

“Монгол цэргийн өдөр”-өөр төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын бие бүрэлдэхүүн Сүхбаатар сумын “Партизаны талбай”-д Сүхбаатар цэргийн хүрээний “Ёслолын жагсаал”, нэгдсэн тооллогыг явууллаа.

Цэргийн штабаас иргэний цэргийн үүргийн биелэлтийг хангуулах, цэргийн бэлтгэл үүрэгтнүүд, иргэдэд энэ талаарх мэдээлэл, зөвлөгөө өгөх зорилгоор “Танд зөвлөө” аяныг энэ сарын 5-ны өдрөөс ирэх 5 дугаар сарын 5-ны өдрийг хүртэлх хугацаанд үргэлжлүүлэн явуулна.

СУРГАЛТАД ХАМРАГДАВ

Зэвсэгт хүчний 325 дугаар анги

Завхан аймгийн Улиастай суман дахь “Ахмад мэргэжилтний холбоо” төрийн бус байгууллагын тэргүүн Э.Цэрэндулам болон мэргэжилтэн Н.Эрдэнэцэцэг нар энэ сарын 21-ний өдөр “Эршүүд байдал ба жендер суурилсан хүчирхийлэл” гэсэн сэдвээр сургалт зохион байгууллаа. Уг сургалтад ангид гэр бүлээрээ ажилладаг офицер, ахлагч буюу 15 гэр бүл хамрагдав.



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 101 ЖИЛИЙН ОЙН ХҮРЭЭНД ДҮҮРГҮҮДЭД ЗОХИОГДСОН ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭНҮҮД

“Монгол цэргийн өдөр”-ийг угтаж нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабууд Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах үйл ажиллагааг 2 дугаар сарын 10-ны өдрөөс энэ сарын 21-ний өдрүүдэд төлөвлөгөөний дагуу явуулж, 96,3 хувьтай зохион байгууллаа.

АЖИЛ ХЭРГИЙН УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн гишүүд, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн гишүүдтэй 3 дугаар сарын 14-ний өдөр хамтран ажиллах талаар ажил хэргийн уулзалт зохион байгуулсан нь хамтын ажиллагааг бэхжүүлсэн үр дүнтэй ажил боллоо. Энэ уулзалтад БХЯ-ны сайдын Зөвлөлийн гишүүд, Нийслэлийн ИТХ-ын дарга, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, чиглэл хариуцсан орлогч нар, ЗДТГ-ын дарга оролцлоо.

АХМАДУУДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ

Монгол Улсад “Хурандаа” цол олгож эхэлсний 86 жилийн ойн хүрээнд Нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабуудад ажиллаж байсан хурандаа нар хүндэтгэл үзүүлэн дурсамж уулзалтыг зохион байгуулж, гарын бэлэг гардуулав.

ТАНИН МЭДЭХҮЙН “АХА” ТЭМЦЭЭН



Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас “Монгол цэргийн өдөр”, Зэвсэгт хүчний 101 жил, монгол цэрэг энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойг тохиолдуулан дүүргийн ерөнхий боловсролын Хангай цогцолбор сургуулийн 7-10 дугаар ангийн сурагчдын дунд “АХА” танин мэдэхүйн уралдаан тэмцээнийг зохион байгууллаа. Тэмцээнд 126 сурагч оюун ухаанаа уралдуулан оролцсоноос тэргүүн байрт 10 дугаар ангийн сурагч З.Батлхагва, дэд байрт 8 дугаар ангийн сурагч Б.Чимэгсайхан, гутгаар байрт 7 дугаар ангийн сурагч Э.Наранцацрал нар шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналын эзэд болов.

УРАЛДААНУУДЫГ ДҮГНЭЛЭЭ

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах болон дунд ангийн сурагчдын дунд “Энхийг сахиулагч-Монгол цэрэг 20 жил” сэдэвт зохион бичлэг, “Миний бахархал-Монгол цэрэг” сэдэвт гар зургийн уралдааныг



зохион байгууллаа. Уралдаанд 21 сургуулийн сурагчдын 164 бүтээл ирснээс зохион бичлэгийн уралдааны тэргүүн байрт 32 дугаар сургуулийн 11А ангийн сурагч М.Дөлгөн, дэд байрт 115 дугаар сургуулийн 12^б ангийн сурагч Э.Жаргалсайхан, гутгаар байрт 60 дугаар сургуулийн 12^а ангийн сурагч Э.Баяржавхлан, гар зургийн уралдааны тэргүүн байрт 18 дугаар сургуулийн 7А ангийн сурагч Д.Азжаргал, дэд байрт “Оном” сургуулийн 9^б ангийн сурагч Э.Эрмүүн, гутгаар байрт 52 дугаар сургуулийн 6^б ангийн сурагч С.Мичидмаа нар шалгарчээ.

Мөн Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб, Боловсролын хэлтэстэй хамтран дүүргийн ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдын дунд “Эх орны хүү-Монгол цэрэг” сэдэвт зохион бичлэг, “Монгол цэргийн жавхаа” гар зургийн уралдааныг тус тус зохион байгуулсан бөгөөд шалгарсан бүтээлийн эзэд энэ сарын 18-ны өдөр шагналыг нь гардууллаа. “Эх орны хүү-Монгол цэрэг” зохион бичлэгийн уралдааны тэргүүн байрт ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн 12^а ангийн сурагч М.Намуунзул, дэд байрт 1 дүгээр сургуулийн 11^б ангийн сурагч С.Саруул, гутгаар байрт 6 дугаар сургуулийн 12^б ангийн сурагч М.Энхжин, “Монгол цэргийн жавхаа” гар зургийн уралдааны тэргүүн байрт ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн 12^б ангийн сурагч М.Дөлгөн, дэд болон гутгаар байрт Монгол-Хятадын найрамдал сургуулийн 10^а ангийн сурагч Ц.Намуунаа, Н.Хулан нарын бүтээлүүд тус тус шалгарсан юм.

“ЦЭРГИЙН АЛДАР” ТЭМЦЭЭНИЙГ 9 ДЭХ ЖИЛДЭЭ ...

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб бэлтгэл хурандаа Р.Нэргүйн нэрэмжит “Цэргийн алдар” тэмцээнийг 3х3 сагсан бөмбөг, гар бөмбөг, дартс, хийн буудлагын төрлөөр зохион байгуулж, 9 багийн 160 гаруй тамирчин авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс багийн дүнгээр тэргүүн байрт Төвийн бүс шалгарч, шилжин явах цомын эзэн боллоо. Мөн Багануур дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабаас төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдлага, тасаг, албадын дарга нарын дунд гар бууны бооцоот буудлага, дартс, снукер биллиардын цогцолбор тэмцээнийг зохион байгуулж, 12 байгууллагын 40 гаруй тамирчин оролцсоноос цогцолбор тэмцээний нийлбэр дүнгээр ИТХ-ын баг тэргүүн байр, Цэргийн штабын баг дэд байр, Хилийн цэргийн 0252 дугаар ангийн баг гутгаар байрыг тус тус эзэлсэн байна.

“МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ” УУЛЗАЛТ ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабаас дүүргийн их, дээд сургуулиудын оюутнуудад батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах, эх оронч, үндэсний түүх соёл, уламжлалаар бахархах үзэл санаа төлөвшүүлэх зорилгоор “Монгол Улсынхаа төлөө зүтгээ” уулзалт өдөрлөгийг зохион байгууллаа. Уг уулзалт өдөрлөгт ҮБХИС-ийн профессор, хурандаа Г.Бүлтэн, Монгол хурандаа нийгэмлэгийн ерөнхий менежер Л.Амарсайхан, Хилийн цэргийн бэлтгэл хурандаа П.Болор, Чингис СООСЭ Олон улсын харилцааны сургуулийн Аюулгүй байдал-хууль сахиулахын хөтөлбөрийн багийн багш, бэлтгэл хурандаа Г.Ганбат нар “Эх оронч үзэл, зөв төлөвшил хүмүүжил” сэдвээр лекц, ярилцлага, Цэргийн штабын тоо бүртгэлийн офицер хошууч Б.Гансүх “Батлан хамгаалах багц хууль”-ийн талаар танилцуулга хийж 2022 онд 18 нас хүрч буй оюутнуудад цэргийн үүрэгтний үнэмлэхийг гардуулан өгсөн. Мөн шуулиар хүлээсэн иргэний цэргийн үүргээ биелүүлж, хугацаат цэргийн алба хаасан оюутан Б.Түвшинжаргал цэргийн алба хаасан сэтгэгдлээ үеийн нөхдөдөө хуваалцлаа. Тус өдөрлөгт дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Чингис” СООСЭ Олон улсын харилцааны сургууль, “Ач” Анагаах ухааны дээд сургууль, Монос эм зүйн шинжлэх ухааны их сургууль, Шинэ анагаах ухааны их сургуулийн оюутнууд оролцсон бөгөөд тэдэнд Батлан хамгаалах хууль тогтоомжийн гарын авлагыг олгосон байна. Мөн Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб, Боловсролын хэлтэстэй хамтран ерөнхий боловсролын 2, 31 дүгээр сургуулийн ахлах

ангийн сурагчдын дунд “Хүүхэд, залуучуудад эх оронч үндэсний үзлийг төлөвшүүлэх” хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд бэлтгэл хошууч генерал Б.Баярмагнай урьж уулзалт зохион байгууллаа. Тэрээр “Монгол хүний үнэ цэн ба Эх оронч үндэсний үзэл” сэдвээр яриа таниулга хийсэн юм. Багануур дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб, дүүргийн Ахмадын хороотой хамтран хүүхэд залууст эх оронч үзэл төлөвшүүлэх, батлан хамгаалах бодлого зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах зорилгоор дүүргийн ерөнхий боловсролын “Боловсрол цогцолбор” сургуулийн төгсөх ангийн сурагчдыг хамруулан “Эх оронч хүмүүжил” сэдэвт лекцийг зохион байгууллаа.

БАЙЛДАГЧИД НАР АР ГЭРИЙНХЭНТЭЙГЭЭ УУЛЗЛАА

Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб, “Чингис СООСЭ” олон улсын харилцааны сургуультай хамтран 2021 оны хоёрдугаар ээлжээр хугацаат цэргийн албанд татагдсан байлдагчдын ар гэрт тусламж үзүүлэх сайн үйлсийн аяныг зохион байгууллаа. Аяны хүрээнд Зэвсэгт хүчний 013, 311 дүгээр ангид алба хааж буй хоёр байлдагч нэг өдрийн чөлөө эдэлж ар гэрийнхэнтэйгээ баяр хөөртэйгөөр уулзсан юм.

“ИРГЭНИЙ ЦЭРГИЙН ҮҮРЭГ-ЦЭРГИЙН ШТАБ” СЭДЭВТ ЗОХИОН БИЧЛЭГИЙН УРАЛДААН БОЛЛОО

Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабаас Монгол хүн болж төрсөн бахархлыг тээгч байх үндэсний хөтөлбөрийн хүрээнд хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх зорилгоор дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Иргэний цэргийн үүрэг-Цэргийн штаб” сэдэвт зохион бичлэг, “Би эх орны хүү” богино видео бичлэгийн уралдааныг 2 дугаар сарын 12-ны өдрөөс энэ сарын 12-ны өдрүүдэд зохион байгуулж, тэмцээний шагналыг 14-ний өдөр болсон “Мөрдэс нэгт цэргийн андууд” арга хэмжээний үеэр гардуулан өглөө. “Иргэний цэргийн үүрэг-Цэргийн штаб” сэдэвт зохион бичлэгийн уралдааны тэргүүн байрт 122 дугаар сургуулийн 11а ангийн сурагч Г.Нямжав, дэд байрт 65 дугаар сургуулийн 11а ангийн сурагч Л.Энхбаяр, гутгаар байрт 12 дугаар сургуулийн 11а ангийн сурагч Б.Уянгаланхуа, тусгай байрт 104 дүгээр сургуулийн 12б ангийн сурагч Д.Нандинцэцэг нар шалгарлаа. Мөн “Би эх орны хүү” видео бичлэгийн уралдааны тэргүүн байрт “Хөгжил цогцолбор” сургууль, дэд байрт 123 дугаар сургууль, гутгаар байрт 129 дүгээр сургууль, тусгай байрт 12 дугаар сургуулийн сурагчдын бүтээлүүд шалгарчээ.

МӨРДЭС НЭГТ АНДУУД ЧУУЛЖЭЭ



Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас “Мөрдэс нэгт цэргийн андууд” сэдэвт уулзалт өдөрлөгийг Дотоодын цэргийн 05 дугаар ангийн байрлалд зохион байгууллаа. Тус арга хэмжээнд Сонгинохайрхан дүүргийн удирдлага, Зэвсэгт хүчний 013, 017 дугаар анги, Дотоодын цэргийн 05 дугаар анги, Хилийн 151 дүгээр анги, Үндэсний аврах бригад, Цагдаагийн газрын төлөөлөл болон бэлтгэл чөлөөнд байгаа ахмадууд, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, хугацаат цэргийн алба хаагчид оролцлоо. Арга хэмжээний үеэр эрхэлсэн ажилдаа идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллаж байгаа алба хаагчдыг дүүргийн Иргэдийн хурлын Хүндэт тэмдэг, дүүргийн Засаг даргын Хүндэт өргөмжлөлөөр шагнав. Мөн цэргийн анги, байгууллагуудын уран бүтээлчдийн хамтарсан урлагийн тоглолт, Дотоодын цэргийн 05 дугаар ангийн зэвсэг, техник, хувцас хэрэгслийн үзэсгэлэн, хугацаат цэргийн алба хаагчдын үзүүлэх тоглолтыг зочид төлөөлөгчдөд үзүүлж сонирхууллаа.